

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

**Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Мандал Даатгал ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1 ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг

сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.10 дахь хэсэг, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, 8-р зүйлийн 8.4 дэх хэсэг, 2021 оны 04 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай:

а. Ноён	Ө.Ганзориг (ердийн гишүүн)
б. Хатагтай	Ш.Шаравпэлжээ (ердийн гишүүн)
в. Ноён	О.Ганжолоо (ердийн гишүүн)
г. Ноён	А.Амундра (ердийн гишүүн)
д. Ноён	Ч.Ванчин-Эрдэнэ (ердийн гишүүн)
е. Ноён	Б.Жавхлан (ердийн гишүүн)
ё. Ноён	Жэймс Бернард Двайер (хараат бус гишүүн)
ж. Ноён	Ж.Дэлгэрсайхан (хараат бус гишүүн)
з. Ноён	Н.Мандуул (хараат бус гишүүн)

2. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай:

а. Ноён	Ө.Ганзориг
б. Хатагтай	Ш.Гантуяа
в. Ноён	О.Ганжолоо
г. Ноён	О.Мөнхжаргал
д. Ноён	Л.Ганзоригт
е. Ноён	Б.Жавхлан

3. Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай:

а. Ноён	Жэймс Бернард Двайер
б. Ноён	Ж.Дэлгэрсайхан
в. Ноён	Г.Гантулга

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Энхтүвшин) нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2019 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №19/002 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Мандал Даатгал ХК-ийн дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 7-р зүйлийн 7.7.1 дэх хэсэг, 2021 оны 04 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

“ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;”

2. Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хассугай.

3. Компанийн дүрмийн 7.16-р зүйлд дараахыг нэмж оруулсугай:

“Компанийн ТУЗ-ийн шийдвэр гарсан эсхүл ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн эсхүл нийт саналын эрхийн 10 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс ТУЗ-д шаардлага гаргасан тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.”

4. Компанийн дүрмийн 13.1.3-р зүйлд дараахыг нэмж оруулсугай:

“Санхүү хариуцсан захирал;”

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Энхтүвшин) нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

**Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны**

**зардлын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дэх хэсэг, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2019 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №19/002 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дэх хэсэг, 2021 оны 04 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, цалин, урамшуулал	154,000,000
2	Бичиг хэргийн зардал	1,000,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	2,000,000
	<b>Дүн</b>	<b>157,000,000</b>

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ